# ИНТЕРНЕТ БАНКНЫ НУУЦ ҮГ СЭРГЭЭХ ЗААВАРЧИЛГАА

Харилцагч та интернэт банкны нууц үгээ блоклосон эсвэл нууц үгээ мартсан бол нэвтрэх нууц үг болон гүйлгээний нууц үгээ дараах зааврын дагуу өөрөө сэргээж, интернэт банкаа ашиглаарай.







## АЛХАМ 1

Харилцагч та www.khanbank.com хаягаар эсвэл 'Khan Bank' ухаалаг аппликейшний 'Нууц үг мартсан' хэсгийг сонгоно.

*Санамж:*

- *Интернэт банкны үйлчилгээнд бүртгүүлсэн өөрийн и-мэйл хаягаа шалгах боломжтой байхыг анхаарна уу.*
- *Интернэт банкны үйлчилгээний нэвтрэх нэрээ мэддэг байхыг анхаарна уу.*




## АЛХАМ 2

Интернэт банк үйлчилгээний нэвтрэх нэр, өөрийн регистрийн дугаараа оруулан идэвхжүүлэх кодыг бичнэ. Дараа нь үргэлжлүүлэх товчийг дарна.

*Санамж:*

- *Регистрийн дугаарыг крилл үсгээр том, жижиг аль ч хэлбэрээр бичиж болно.*




## АЛХАМ 3

Идэвхжүүлэх код и-мэйлээр авах гэсэн сонголтыг сонгон бүртгэлтэй и-мэйл хаягаа оруулна. Баталгаажуулах кодыг дуурайн бичин идэвхжүүлэх код авах хэсгийг дарна.

*Санамж:*

- *Идэвхжүүлэх кодоо и-мэйлээр авах сонголтыг сонгоно уу. Утсаар буюу SMS-ээр авах сонголт тун удахгүй идэвхжих болно.*


ebank Mail [redacted]
Идэвхжүүлэх код
This message was sent with High importance.

Эрхэм хэрэглэгч танд энэ өдрийн мэнд хүргэе!
Таны шинэчлэгдсэн интернет банк буюу [redacted] эрхийг идэвхжүүлэх хүсэлтийг хүлээн авлаа.
Идэвхжүүлэх код: 503296
Та доорх холбоосоор орно уу.
Вэб хаяг: http://www.khanbank.com
И-мэйл: ebanking@khanbank.com
Харилцагчийн мэдээллийн төв: 1800-1917

## АЛХАМ 4

Харилцагч таны бүртгүүлсэн и-мэйл хаягт Noreply.ebank@khanbank.com хаягнаас идэвхжүүлэх код илгээгдсэн байна. Та и-мэйлээ шалган идэвхжүүлэх кодыг тэмдэглэж эсвэл хуулж аван website-руу буцна.

*Санамж:*

- *Харилцагч та өөрийн интернэт банкны нууц үг, нэвтрэх нэрээ бусдад бүү задруулаарай.*
- *Банк таны хувийн мэдээлэл, нууц үгийг хэзээ ч асуухгүй болохыг анхаарна уу.*




## АЛХАМ 5

Интернэт банкны нэвтрэх нэр, и-мэйлээр ирсэн идэвхжүүлэх кодоо оруулна. Баталгаажуулах кодыг дуурайн бичиж, үргэлжлүүлэх товчийг дарна.




## АЛХАМ 6

Сэргээх нууц үгийн төрлөө сонгон шинэ нууц үгээ оруулна. Дараа нь нууц үг солих хэсгийг дарснаар таны нуу үг солигдоно.

*Санамж:*

- *Нууц үг нь том жижиг үсэг, тоо 8 тэмдэгтээс бүрдсэн байх шаардлагатай.*
- *Нэвтрэх нууц үг гүйлгээний нууц үг нь хоорондоо ялгаатай байхыг анхаарна уу. Интернэт банкны үйлчилгээнд нэвтрэхдээ нэвтрэх нууц үгээ оруулах ба харин гүйлгээ шилжүүлэг хийхэд гүйлгээний нууц үгээ оруулна.*

Харилцагч танд нууц үгээ сэргээхэд асуудал гарсан бол ХААН Банкны Харилцагчийн мэдээллийн төвийн **1800–1917** дугаарт холбогдоно уу.